



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМ-д

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020. 07. 22. № 179.
танай _____-ны № _____-т

Хандивын тайлангийн дүгнэлт

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Монгол ардын намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Монгол ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Тухайн намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулаагүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол ардын намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.


Дүгнэлт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМ нь 2020 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

“Өвөрхангай аймгийн Монгол ардын нам”-аас ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт..... хуудастай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

**Орон нутгийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэлд “ИРГЭН”-ээс
өгсөн хандивын тайлан**

МАЯГТ-1

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМ

/мян.төг/

№	Иргэний овог нэр	Хандив өгсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан		Тайлбар
				Банкны нэр	Дансны дугаар	
Ээлжит сонгуулийн жилийн өмнөх 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон						
1	Байхгүй					
2						
3						
4						
Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-нээс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд						
5	Байхгүй					

Тамга тэмдэг



Албан тушаал

Хянасан:

Өвөрхангай аймгийн МАН-н дэд дарга

Боловсруулсан:

Өвөрхангай аймгийн МАН-н Нягтлан бодогч

Овог нэр

М.Батзориг

Б.Бат-Эрдэнэ

Гарын үсэг

2020 оны 06 дугаар сарын 2 өдөр

**Орон нутгийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэлд “ХУУЛИЙН ЭТГЭЭД”-ээс
өгсөн хандивын тайлан**

МАЯГТ-2

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМ

/мян.төг/

№	Хуулийн этгээдийн нэр	Хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл				Хандив хүлээн авсан			Мөнгөн дүн	Тайлбар
		Регистрийн дугаар	Хаяг, утасны дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Үйл ажилгааны чиглэл	Огноо	Банкны нэр	Дансны дугаар		
Ээлжит сонгуулийн жилийн өмнөх 01дүгээр сарын 01-нээс 12дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон										
1	Байхгүй									
Ээлжит сонгуулийн жилийн 01дүгээр сарын 01-нээс 0. дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд										
1	Байхгүй									


Тамга тэмдэг

Албан тушаал
Хянасан: Өвөрхангай аймгийн МАН-н дэд дарга
Боловсруулсан: Өвөрхангай аймгийн МАН-н Нягтлан бодогч

Овог нэр

М.Батзориг
Б.Бат-Эрдэнэ

Гарын үсэг



2020 оны 06 дугаар сарын 23 өдөр